



“ЦАХИМ ХУДАЛДАА ХАМТЫН ОРОЛЦОО” ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХӨТӨЛБӨР

2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр,
Лхагва гараг

Галлериа Улаанбаатар,
Жуулчин Өргөө танхим

Цаг	Үйл ажиллагаа
08:30-08:55	Оролцогчдын бүртгэл
08:55-09:00	Нээлт: П.Цэрэнням; ХХЗХ-ны ШЗГ-ын дарга
09:00-09:15	Цахим худалдаа & Шуудан Ц.Амгалан; ХХЗХ-ны ШЗГ-ын мэргэжилтэн
09:15-09:30	Тав тухтай цахим шийдэл А.Тэнгисболд; Стора Централ ХХК-ийн Үйл ажиллагаа борлуулалт хариуцсан захирал https://www.stora.mn/
09:30-09:45	Цахим худалдааны боломж ба эрсдлүүд Ч.Даваажамц; “Шоппи” ХХК-ийн Гүйцэтгэх захирал https://shoppy.mn/
09:45-10:00	Цахим худалдаа & шуудангийн үйлчилгээ Б.Цэрэндолгор; Марин Нью Пост ХХК-ийн Гүйцэтгэх захирал https://www temu.com/
10:00-10:15	Эрсдэлийн дүн шинжилгээ хийхэд Шинэ технологийг ашиглах нь Д.Цэндсүрэн; ЕГГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга
10:15-10:30	Цайны завсарлага
10:30-10:45	Жижиг бизнесүүдийг цахим худалдаанд шилжүүлэх нь: Маркетшоп платформын шийдэл Э.Ганзориг; Маркетшоп худалдааны технологи ХХК, Гүйцэтгэх захирал www.market.shop
10:45-11:00	Ecommerce friendly ERP О.Тулга; Смарт Ритэйл Системс ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал
11:00-11:15	Digital Delivery Infrastructure for Mongolia's E-commerce Future Ө.Батзориг; Юубикаб Экспресс ХХК-ийн Гүйцэтгэх захирал
11:15-11:30	Paqu App Г.Лхагвадэлгэр; Номадик Софт ХХК-ийн Гүйцэтгэх захирал
11:30- 11:45	Халдлагад хариу арга хэмжээ авах ажиллагаа / Incident response / И.Нуваанчимэд; Кибер Халдлага, Зөрчилтэй Тэмцэх Нийтийн Төвийн Аюулгүй байдлын шинжээч /OSCP-OffSec Certified Professional/
11:45-13:00	Хэлэлцүүлэг
13:00-13:10	Хаалт: П.Цэрэнням; ХХЗХ-ны ШЗГ-ын дарга

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ИЛТГЭГЧИД



А.Тэнгисболд

Стора Централ ХХК-ийн Үйл ажиллагаа борлуулалт хариуцсан захирал

Мэдээлэл технологийн салбарт 9 жил ажилласан туршлагатай. 2024 оноос эхлэн Stora.mn хамт олонтой нэгдэн Үйл ажиллагаа, борлуулалт хариуцсан захирлаар ажиллаж, хэрэглэгчийн үйлчилгээ, хэрэглэгчийн гарт бараа бүтээгдэхүүн хүрэх хугацааг багасгаж хэрэглэгчид илүү тав тухтай үйлчилгээг хүргэхэд зорин ажиллаж байна.



Б.Цэрэндолгор

Марин Нью Пост ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Барилга, мэдээллийн технологийн салбарт 10 жил ажилласан туршлагатай. 2024 оноос “Цахим худалдааны бараа бүтээгдэхүүнийг шуудангийн үйлчилгээгээр хэрэглэгчид хүргэх” төслийн системийн шинжилгээ, бизнес процессыг зохион байгуулах ажлыг гүйцэтгэсэн. Цаашид уг төслийг улам илүү хөгжүүлэх, зүгшрүүлэх ажлуудыг гүйцэтгэж байна.



Г.Лхагвадэлгэр

Номадик Софт ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Software developer, entrepreneur
Paky.app -ийн үүсгэн байгуулагч



Д.Цэндсүрэн

ГЕГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга

1995 оноос хойш гаалийн байгууллагад ажиллаж буй туршлагатай. 2017 оноос хойш Дэлхийн Гаалийн Байгууллагын эрсдэлийн удирдлагын техникийн болон үйл ажиллагааны зөвлөхөөр ажиллаж байгаа бөгөөд худалдааг хөнгөвчлөх, эрсдэлийн удирдлага, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж зэрэг чиглэлээр үндэсний болон олон улсын түвшинд мэргэшин ажиллаж байна.



И.Нуваанчимэд

Кибер Халдлага, Зөрчилтэй Тэмцэх Нийтийн Төвд Аюулгүй байдлын шинжээч

Кибер Халдлага, Зөрчилтэй Тэмцэх Нийтийн Төвд аюулгүй байдлын шинжээчээр 6 дахь жилдээ ажиллаж байна.

OSCP-OffSec Certified Professional

OSWE - Offsec Web Expert certificate verified



О.Тулга

Смарт Ритэйл Системс ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал

2013 оноос хойш програм хангамж хөгжүүлэлтийн чиглэлээр ажиллаж байгаа туршлагатай. 2018 оноос Смарт Ложик ХХК, Smart ERP дэлгүүр, Хүний нөөц, Лоялти, Цаг бүртгэл, Захиалгын систем зэрэг бүтээгдэхүүнүүд дээр системийн шинжээч болон төслийн менежерээр ажиллаж, 2024 оноос Смарт Ритэйл Системс ХХК-д Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байна.



Ө.Батзориг

Юубикаб Экспресс ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Олон Улсын Бизнесийн Удирдлагын боловсролтой бөгөөд Erdenet Carpet LLC, Natural Textile Group, AODE EQUIPMENT LLC зэрэг байгууллагад маркетинг, борлуулалтын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай. Явган хүргэлтийн системийг байгальд ээлтэй шийдэл болгон онцолж, хэрэглэгчийн туршлагыг сайжруулахад технологийн үүргийг онцолж байна.



Ц.Амгалан

ХХЗХ-ны ШЗГ-ын Шуудангийн цахим үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Харилцаа холбооны салбарт 16 жилийн туршлагатай. Шуудангийн цахим үйлчилгээ болон цахим худалдааны чиглэлээр мэргэшсэн. “Цахим худалдаа ба ногоон шуудан”, “Цахим худалдааны зөвлөмж” боловсруулан гаргасан. Салбарын хөгжлийг дэмжих, цахим шийдлүүдийг нэвтрүүлэхэд идэвхтэй оролцож ирсэн.



Ц.Даваажамц

“Shoppu” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Технологийн салбарт бизнес хөгжүүлэлт, зөвлөгөө, хөрөнгө оруулалтын чиглэлээр ажилласан туршлагатай. Одоо үндэсний цахим худалдааны shoppu.mn компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. “Dropship” худалдаа болон цахим худалдааны үйл ажиллагааг сайжруулахаар ажиллаж байна.



Э.Ганзориг

Маркетшоп худалдааны технологи ХХК, Гүйцэтгэх захирал

2018 онд Market.mn сайтыг хамтран үүсгэн байгуулж, 7 жил цахим худалдаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн чиглэлээр ажилласан. 2022 оноос жижиг бизнесүүдийн цахим худалдааг хөнгөвчлөх шийдэл болох Маркетшоп платформыг хамтран үүсгэн байгуулж, гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Цахим худалдааны экосистемийг Монголд бүрдүүлэх, бизнесүүдийг онлайнаар амжилттай ажиллах нөхцөлөөр хангах зорилготой.